

Маргааны товч:

“Ондо” ХХК нь “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 4.5-д “Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтын дагуу технологиос үл хамаарах зарчмыг баримтлан хүснэгт 2-т үзүүлсэн радио давтамжийн зурвасыг 4G, 5G сүлжээнд хэсэгчлэн болон бүрэн зурвасаар шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль журмын дагуу оруулж ашиглана” гэж заасныг, мөн шаардлагын 4.3-ын хүснэгт 2, 4.8-ын хүснэгт 3-ыг тус тус хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ “... Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтаар олгохоор заасан радио давтамжийн зурвасыг маргаан бүхий заалтаар сонгон шалгаруулалтгүйгээр шилжүүлэх замаар олгохоор зохицуулсан нь хууль зөрчсөн. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон радио давтамжийн зурвасыг шилжүүлэн ашиглахыг зөвшөөрсөн хуулийн ямар ч зохицуулалт байхгүй. Цахим хөгжил, харилцаа холбооны яам Үндэсний хүснэгт батлан мөрдүүлсний үндсэн дээр сонгон шалгаруулалтын журмаар радио давтамж хуваарилагдахаар байтал Харилцаа холбооны зохицуулах хороо нь маргаан бүхий заалтыг баталж зах зээлд давамгайл байдалтай, хамгийн их давтамж эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдэд давуу байдал олгож байгаа нь шударга бус, үүний улмаас тус салбарт сүүлд орж ирсэн манай (жижиг) компанийн эрх ашиг зөрчигдөж байна... Мөн 4.3 дахь заалтын Хүснэгт 2, 4.8 дахь заалтын Хүснэгт 3 нь төлөвлөлт, хуваарилалтын агуулгатай нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ буюу “журам” байна. Үүнийг төрийн захиргааны төв байгууллага буюу яам батлах ёстой байтал хариуцагч Харилцаа холбооны зохицуулах хороо баталсан нь өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлсэн хууль бус байна ...” гэх агуулгаар маргасан.

Хариуцагчаас “... Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Бодлогын чиглэл, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тус тус үндэслэн “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Маргаан бүхий 4.5 дахь заалт нь бодлогын чиглэлийн дагуу оператор компаниуд нь өмнөх үеийн хөдөлгөөнт холбоо буюу 2G, 3G-д одоо ашиглаж буй радио давтамжаа уг тусгай зөвшөөрлийнхөө хүчинтэй хугацаандаа дараа үеийн хөдөлгөөнт холбоо буюу 4G, 5G сүлжээнд шилжүүлэн ашиглах боломжтойг сануулсан заалт тул нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөөгүйгээс гадна радио давтамжийн эрэлт хэрэгцээ, үр ашгийг нэмэгдүүлэх зохицуулалт юм... Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}-т заасан эрхийнхээ хүрээнд дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвасыг салган авч, зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлж баталдаг...” Иймд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан хууль ёсны шийдвэр тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэх агуулгаар маргажээ.